



# БУЛГАН АЙМГИЙН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДАЛ

## 2016/2



# СТАТИСТИК МЭДЭЭЛЛИЙГ ХЭРХЭН АВАХ ВЭ?


[www.1212.mn](http://www.1212.mn)





СТАТИСТИКИЙН МЭДЭЭЛЛИЙН  
НЭГДСЭН САН



[www.nso.mn](http://www.nso.mn) сайтын  
Хэрэглэгчийн бүртгэлд  
бүртгүүлснээр цахим  
хаягаар тогтмол  
авч болно.



Monstat ezStat  
аппликейшн



1900-1212



Лавлах утас



Үндэсний Статистикийн  
Хорооны  
НОМЫН САН



Онлайн лавлах  
мессенжер  
8:30-17:30

@statistic\_mn



Статистик  
мэдээлэл

ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭГ

ХҮНД СУРТАЛ  
АВИЛГА

ҮГҮЙ НЭЭЛТТЭЙ  
ХҮРГЭНЭ

## ГАРЧИГ

Аргачлалын тайлбар.....	2
Товч танилцуулга.....	5
Үндсэн үзүүлэлтүүд.....	12
I. 1 Хөдөлмөр .....	13
I. 2 Нийгмийн даатгал.....	13
I. 3 Эрүүл мэнд .....	14
I. 4 Гэмт хэрэг .....	15
II.2 Үнэ.....	16
II.6 Мал аж ахуй.....	21

## Аргачлалын тайлбар

### Хөдөлмөр

Бүртгэлтэй ажилгүй иргэдэд Монгол Улсын хуулиар зөвшөөрөгдсөн хөдөлмөрлөх насны, хөдөлмөр эрхлэх чадвартай, цалин хөлстэй ажил болон хувиараа хөдөлмөр эрхлэгдэггүй, тухайн үед ажиллахад бэлэн, цалин хөлстэй ажил идэвхитэй хайж байгаа хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтэс, хөдөлмөрийн төв бирж, хөдөлмөрийн хувийн биржид бүртгүүлсэн ажилгүй иргэдийг хамруулна.

### Нийгмийн даатгал, халамж

Нийгмийн даатгал нь иргэн болон төр, аж ахуйн нэгж байгууллагаас зохих журмын дагуу шимтгэл төлж, нийгмийн даатгалын сан бүрдүүлэх, даатгуулах, өндөр наслах, хөдөлмөрийн чадвараа алдах, өвчлөх, ажилгүй болоход өөрт нь, тэрчлэн даатгуулагч нас барахад түүний асрамжид байсан хүмүүст хууль тогтоомжид заасан тэтгэвэр, тэтгэмж, төлбөр өгөх агуулга бүхий нийгэм эдийн засгийн арга хэмжээ юм. Тэтгэврийн, тэтгэмжийн, эрүүл мэндийн, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалан өвчний, ажилгүйдлийн даатгал гэсэн төрлөөс нийгмийн даатгал бүрдэнэ.

Нийгмийн даатгалын сан нь ажил олгогч, даатгуулагчийн хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогоос тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, үйлчилгээнд зарцуулах болон нийгмийн даатгалын үйл ажиллагааны зардлыг нөхөх зорилгоор төлсөн шимтгэлийн орлого, бусад эх үүсвэрээс бүрдэнэ.

Нийгмийн даатгалын тухай хууль болон гэрээний үндсэн дээр нийгмийн даатгалын санд нийгмийн даатгалын шимтгэл төлж даатгуулсан, нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж, төлбөр авах эрх бүхий этгээдийг даатгуулагчаар тооцно.

Тэтгэвэр нь даатгуулагчийг өндөр наслахад насан туршид нь, хөгжлийн бэрхшээлтэй болоход хөдөлмөрийн чадвар нь сэргээгдэх хүртэл, нас барахад нь түүний гэр бүлийн хөдөлмөрийн чадваргүй гишүүд (хүүхэд 16 нас, сургуульд суралцаж байгаа бол 19 нас хүртэл)-ийн нийгмийн баталгааг хангах зорилгоор нийгмийн даатгалын сангаас олгох мөнгөн хөрөнгө байна.

Тэтгэмж нь хөдөлмөрийн чадвараа түр алдах, жирэмслэх, амаржих, нас барах тохиолдолд даатгуулагчид нийгмийн даатгалын сангаас нэг удаа олгох мөнгөн хөрөнгө байна.

Нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа шаардлагатай хүнд хуульд заасан тэтгэвэр, нөхцөлт мөнгөн тэтгэмж олгох, олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн болон төрөлжсөн асрамжийн үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагааг нийгмийн халамж гэнэ.

### Эрүүл мэнд

Жирэмслэлтийн хугацаанаас хамаарахгүйгээр ердийн төрөлтөөр эсвэл мэс ажилбараар ургийг умайнаас гарган авсны дараа нярай амьсгалж байсан эсвэл амьдын бусад ямар нэгэн шинж тэмдэг, өөрөөр хэлбэл, зүрхний цохилт, хүйний судасны лугшилт, булчингийн тодорхой хөдөлгөөн илэрч байвал хүй эсвэл эхэсийг салгасан эсэхийг харгалзахгүйгээр амьд төрөлтөд тооцно.

Амьд төрсөн 1000 хүүхдэд ногдох нялхсын эндэгдлийг тодорхойлохдоо тухайн хугацаанд 1 хүртэлх насандаа эндсэн хүүхдийн тоог амьд төрсөн хүүхдийн тоонд харьцуулна.

Амьд төрсөн 1000 хүүхдэд ногдох хүүхдийн эндэгдлийг тооцохдоо тухайн хугацаанд 5 хүртэлх насандаа эндсэн хүүхдийн тоог амьд төрсөн хүүхдийн тоонд хуваана.

Эндсэн эхийн тоонд жирэмсний хугацаанд болон төрөх үедээ эсвэл төрснөөс хойш 42 хоногийн дотор жирэмслэлтийн байрлал, үргэлжилсэн хугацаанаас үл хамааран жирэмслэлт, төрөлт болон түүнийг удирдахтай холбоо бүхий шалтгаанаар эндсэн эхийг хамааруулна.

Халдварт өвчний өвчлөлийн 10000 хүнд ногдох түвшинг тооцохдоо тайлант хугацаанд амбулаторийн үзлэгээр шинээр бүртгэгдсэн нийт халдварт өвчний тохиодлын тоог тухайн хугацааны хүн амын тоонд харьцуулна.

### Аюулт үзэгдэл, осол

Гамшиг гэж аюулт үзэгдэл, техникийн холбогдолтой осол, алан хядах ажиллагаа, дэлбэрэлтийн улмаас олон хүний эрүүл мэнд, амь нас хохирох, мал амьтан олноор хорогдох, эд хөрөнгө, хүрээлэн байгаа орчинд улс, орон нутгийн дотоод нөөц боломжоос давсан хохирол учрахыг хэлнэ.

Аюулт үзэгдэл гэж хүчтэй цасан болон шроон шуурга, ган, зуд, үер, газар хөдлөлт, цөлжилт болох, гал түймэр, хүн, мал, амьтны болон ургамлын гоц халдварт өвчин гарах, хортон мэрэгчид тархах зэргийг хамруулан ойлгоно. Техникийн холбогдолтой осол гэж үйлдвэрлэл, технологийн горим зөрчигдсөнөөс тоног төхөөрөмж, барилга, байгууламж, шугам, сүлжээ эвдрэх, тээврийн хэрэгсэл осолдох, сүйрэх, цацраг идэвхт болон химийн хорт бодис алдагдах зэргийг хамруулан ойлгоно.

### Гэмт хэрэг

Эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр Монгол Улсын Эрүүгийн хуульд заасан, нийгэмд аюултай, гэм буруутай үйлдэл, эс үйлдэхүйг гэмт хэрэг гэнэ.

Гэмт хэргийн нийгмийн шинж чанар, аюулын хэр хэмжээ, оногдуулж болох ялын хүнд хөнгөнийг харгалзан гэмт хэргийг хөнгөн, хүндэвтэр, хүнд, онц хүнд гэж ангилна.

Гэмт хэргийн тоог Монгол Улсын Эрүүгийн хуульд заасны дагуу гэмт хэргийн төрлөөр нэгтгэн гаргаж байна.

Тухайлбал:

- Хүний ам бие, эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг
- Хүүхэд гэр бүл, нийгмийн эсрэг гэмт хэрэг
- Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг
- Үндэсний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг
- Нийгмийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг
- Хүн амын эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг
- Тээврийн хэрэгслийн хөдөлгөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг
- Шүүн таслах ажиллагааны эсрэг гэмт хэрэг
- Байгаль хамгаалах журмын эсрэг гэмт хэрэг
- Бусад гэмт хэрэг

18 ба түүнээс дээш насны 10000 хүнд ногдох бүртгэгдсэн гэмт хэргийн тоог тодорхойлохдоо нийт бүртгэгдсэн гэмт хэргийн тоог 18 ба түүнээс дээш насны хүн амын дундаж тоонд харьцуулна.

Дор дурьдсан этгээдэд хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч эрүүгийн хэрэг үүсгэж, үндэслэл бүхий тогтоол гаргасан бол сэжигтнээр тооцно. Үүнд:

-Уг этгээдийг гэмт хэрэг үйлдэж байх үед буюу үйлдэл дор нь барьсан

-Гэмт хэрэг үйлдсэн этгээдийг хохирогч буюу харсан хүн шууд заасан

-Уг этгээдийн бие, хувцас, эд зүйл, орон байранд гэмт хэргийн ул мөр тодорхой илэрч олдсон

-Уг этгээд хэргээ илчлэн ирсэн

-Гэмт хэрэгт сэрдэгдэх үндэслэл бүхий бусад баримт байгаа бол

Хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч тогтоол үйлдэж, ял сонгосон этгээдийг яллагдагчаар тооцно.

### Төрийн санхүү

Орон нутгийн төсвийн суурь орлого гэж тухайн шатны төсөвт орох татварыг доод хувь хэмжээгээр тооцсон орлого болон татварын бус орлогын нийлбэрийг хэлнэ.

Орон нутгийн суурь зарлага гэж сум, аймаг, нийслэлийн удирдлагыг хэрэгжүүлэх чиг үүрэгтэй холбогдох урсгал болон хөрөнгийн зарлага, нийгмийн асрамж, халамжийн үйлчилгээ, байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх зардлыг хэлнэ.

Төсвийн тэнцэл гэж тухайн төсвийн жил, улирлын нийт орлого, зарлагын зөрүүг хэлнэ.

Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас батлан аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга бүрдүүлж зарцуулах төсөв нь орон нутгийн төсөв байна.

Татварын орлогод орлогын албан татвар, нийгмийн даатгалын шимтгэл, хураамж, өмчийн татвар, дотоодын бараа, үйлчилгээний татвар, гадаад худалдааны татварын орлого болон бусад татвар орно.

Төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгжийн төрийн өмчид ногдох хувьцааны ногдол ашиг, хүү, торгуулийн орлого, түрээсийн орлого, төсөвт газрын өөрийн орлого болон татварын бус бусад орлогоос татварын бус орлого бүрдэнэ.

Төсвийн зарлагыг урсгал зардал, хөрөнгийн зардал, цэвэр зээл гэж ангилна.

Бараа, үйлчилгээний зардал, зээлийн үйлчилгээний төлбөр, татаас ба урсгал шилжүүлгээс урсгал зардал бүрдэнэ.

### Үнэ

Хэрэглээний үнийн индекс (ХҮИ) нь хэрэглэгчдийн худалдаж авсан бараа, үйлчилгээний нэр төрөл, чанар өөрчлөлтгүй тогтвортой байхад үнэ дунджаар хэрхэн

өөрчлөгдөж буйг хэмжих үзүүлэлт бөгөөд нийт өрхөөр тооцсон үнийн өөрчлөлтийг харуулна.

ХҮИ-ийн тооцоонд хэрэглээний сагс, хэрэглээний жин гэсэн хоёр үзүүлэлтийг ашиглана.

Хэрэглээний сагс нь дундаж зарлагатай өрхийн хэрэглээг төлөөлөх чадвартай, хэрэглээний үнийн индекс тооцох зорилгоор бүрдүүлсэн хүн амын өргөн хэрэглээний бараа, үйлчилгээний үнийн өөрчлөлтийг тооцоход бараа, үйлчилгээний тоо хэмжээ, төрөл, чанар зэргийг тогтмолоор авч үздэг.

Хэрэглээний бараа үйлчилгээний жин гэж өрхийн худалдаж авсан бараа, үйлчилгээний нийт зардалд тухайн бараа, үйлчилгээний зардлын эзлэх хувийн жин юм.

ХҮИ-ийн тооцоонд Ласпейресийн үнийн индексийн томъёог ашиглаж болно.

$$I_p^L = \frac{\sum_{i=1}^n p_{it} * q_{io}}{\sum_{i=1}^n p_{io} * q_{io}}$$

$I_p^L$  -  $t$  тайлант үеийн Ласпейресийн үнийн индекс

$t$  - тайлан үе

$o$  - суурь үе

$p_{it}$  - 'i' барааны тайлант үеийн үнэ,

$p_{io}$  - 'i' барааны суурь үеийн үнэ,

$q_{io}$  - 'i' барааны суурь үеийн худалдан авсан тоо, хэмжээ,

$\sum$  - нийлбэрийн тэмдэг

### Аж үйлдвэр

Аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл нь аж ахуйн нэгжүүдийн тайлант хугацаанд зах зээлд болон өөрийн эцсийн хэрэглээнд зориулж үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээс бүрдэнэ.

Аж үйлдвэрийн салбарын борлуулсан бүтээгдэхүүн нь аж ахуйн нэгжүүдийн

тайлант хугацаанд худалдсан буюу гадагш гүйцэтгэсэн ажил, үйлчилгээний хэмжээ юм.

Аж ахуйн нэгжүүдийг эдийн засгийн үйл ажиллагаагаар нь ангилахдаа НҮБ-аас гишүүн орнууддаа мөрдөхийг зөвлөмж болгосон эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны олон улсын стандарт ангилалд үндэслэсэн үндэсний ангиллыг мөрдөж байна.

### Ерөнхий тэмдэглэл

I. Саруудыг ром тоогоор тэмдэглэв (I, II, III, IV, V... гэх мэт)

Тухайн сарыг оруулсан жилийн эхнээс өсөн нэмэгдэх дүнг харуулахдаа I-IV, I-X зэргээр илэрхийлэв.

II. Дараах тэмдэглэлийг ашиглав:

... мэдээлэл байхгүй

0.0 маш бага тоо

- гүйцэтгэл байхгүй

III. Орон дэвшүүлэлтээс хамаарч зарим үзүүлэлтийн нийлбэр нь дүнтэйгээ, бүтцийг хувиар илэрхийлэхэд 100 хувиас бага зэрэг зөрүүтэй байж болно.

## I. Нийгмийн үзүүлэлт



### I.1 Бүртгэлтэй, ажилгүй иргэн

Аймгийн хөдөлмөрийн хэлтэст бүртгүүлсэн ажил хайгч иргэд 2016 оны эхний 2 дугаар сарын байдлаар 573 болсны 263 нь эмэгтэйчүүд байна. Тайлант хугацаанд 120 иргэн шинээр бүртгүүлж, бүртгэлтэй байсан 6 иргэн ажилд зуучлагдан орж, 251 иргэн ажил идэвхитэй хайхгүй байгаа шалтгаанаар бүртгэлээс хасагдсан нь өмнөх оны мөн үеийнхээс шинээр бүртгүүлсэн ажилгүй иргэнд 42 хүн буюу 25.9 хувь, ажилд зуучлагдан орсон иргэд 12 хүн буюу 66.6 хувь буурч, ажил идэвхитэй хайхгүй байгаа шалтгаанаар бүртгэлээс хасагдсан иргэд 161 хүнээр буюу 78.8 хувиар өсчээ.

Зураг I.1

Хөдөлмөрийн хэлтэст шинээр бүртгүүлсэн, ажилд зуучлагдан орсон болон хасагдсан иргэд жил бүрийн эхний 2-р сарын байдлаар



Бүртгэлтэй ажилгүй иргэдийн 0.2 хувийг Магистр болон докторын зэрэгтэй, 21 хувийг бакалаврын болон дипломын боловсролтой, 3.8 хувийг тусгай мэргэжлийн дунд, 8.6 хувийг техникийн болон мэргэжлийн, 52.5 хувийг бүрэн дунд боловсролтой, 9.0 хувийг суурь боловсролтой, 3.2 хувийг бага боловсролтой, 1.6 хувийг боловсролгүй иргэд эзэлж байна.

Зураг I.2

Бүртгэлтэй ажилгүй иргэд, боловсролын түвшнээр 2016 оны эхний 2-р дугаар сарын байдлаар, хувиар



Эх үүсвэр: Хөдөлмөрийн хэлтсийн сар бүрийн мэдээ 2-р сарын эцэст бүртгэлтэй ажилгүй иргэдийн 12.9 хувийг 15-24 насны, 34.6 хувийг 25-34 насны, 30.5 хувийг 35-44 насны, 17 хувийг 45-54 насны, 4.1 хувийг 55-59 насны, 0.9 хувийг 60-аас дээш насны хүмүүс эзэлж байна.



### I.2. Нийгмийн даатгал, халамж

#### Нийгмийн даатгал

Нийгмийн даатгалын сангийн орлого 2016 оны эхний 2 сард 1801.5 сая төгрөг, зарлага 4835.9 сая төг болж өмнөх оны мөн үеийнхээс орлого 262.5 сая төг буюу 17.1 хувь, зарлага 599.6 сая төг буюу 14.2 хувиар өслөө. Нийгмийн даатгалын сангийн орлого 262.5 сая төгрөгөөр өсөхөд тэтгэмжийн даатгалын сангийн орлого 40.1 сая.төг буюу 34.9 хувиар, ажилгүйдлийн даатгалын сан 19.2 сая.төг буюу 70.8 хувиар, ҮОМШӨ–ний даатгалын сан 22.1 сая.төг буюу 30.9 хувиар, эрүүл мэндийн даатгалын сан 190.8 сая. төг буюу 58.4 хувиар өссөн нь голлон нөлөөлсөн байна. Харин тэтгэврийн даатгалын сан 9.7 сая.төг буюу 1 хувиар буурсан байна. Нийгмийн даатгалын сангийн зарлага өмнөх оны мөн үеийнхээс 599.6 сая. төг буюу 14.2 хувиар нэмэгдэхэд тэтгэврийн даатгалын сангийн зарлага 583.8 сая.төг буюу 15.6 хувиар, ҮОМШӨ даатгалын сан 4.9 сая.төг буюу 14.9 хувиар, эрүүл мэндийн даатгалын сан 46.9 сая.төг буюу 18.2 хувиар, ажилгүйдлийн даатгалын сан 10 сая.төг буюу 36.6 хувиар өссөн нь нөлөөлөв. Харин тэтгэмжийн даатгалын сан 46 сая.төг буюу 26.1 хувиар буурсан байна.

### Нийгмийн халамж

Нийгмийн халамжийн сангаас 2016 оны эхний 2 сард 571.8 сая төгрөгийн тэтгэвэр, тэтгэмж олгосон бөгөөд өмнөх оны мөн үеийнхээс 52.4 сая.төг буюу 10.1 хувиар өсчээ. Үүний 22.1 сая.төг буюу 8.8 хувийг халамжийн тэтгэвэр, 19.4 сая.төг буюу 10.6 хувийг нь нөхцөлт мөнгөн тэтгэмжинд зарцуулсан байна. Халамжийн сангаас олгосон нөхцөлт мөнгөн тэтгэмжийн 33.5 хувийг ахмад настанг асарч буй иргэнд олгосон тэтгэмж, 13.8 хувийг хөгжлийн бэрхшээлтэй иргэнд олгосон тэтгэмж, 13.1 хувийг бүтэн өнчин хүүхэд өсөгсөний тэтгэмж эзэлж байна.




### 1.3 Эрүүл мэнд

Аймгийн хэмжээнд 2016 оны эхний 2 сарын байдлаар 144 эх амаржиж, амьд төрсөн хүүхдийн тоо 145 болж, өмнөх оны мөн үеийнхээс амаржсан эхийн тоо 40 буюу 28 хувь, амьд төрсөн хүүхдийн тоо 38 буюу 26 хувиар буурсан байна.

Зураг 1.3


Амаржсан эх, амьд төрсөн хүүхэд, сүүлийн 3 жилийн 2-р сарын байдлаар



Нялхасын эндэгдэл 2016 оны эхний 2 сарын байдлаар 1 болж, өмнөх оны мөн үеийнхээс 2 буюу 66 хувиар буурсан байна. 1000 амьд төрөлтөд ногдох нялхсын эндэгдэл 1 тохиолдол, 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл одоогоор гараагүй байна.

Зураг 1.4


Эндсэн хүүхэд, сүүлийн 3 жилийн 2-р сарын байдлаар



Халдварт өвчнөөр өвчлөгсөд 2016 оны эхний 2 сарын байдлаар 76 болж, өмнөх оны мөн үеийнхээс 22 тохиолдол буюу 32 хувиар өссөн байна. Нийт халдварт өвчнөөр өвчлөгсдийн 26 буюу 44 хувь нь бэлэгсийн замын халдварт өвчнөөр өвчилсөн байна.

Зураг 1.5

Халдварт өвчнөөр өвчлөгсөд, сүүлийн 3 жилийн 2-р сарын байдлаар



### 1.4 Байгаль орчин

#### Цаг уурын урьдчилсан мэдээ

Гуравдугаар сард. Сарын эхээр болон 24-26-нд харьцангуй


дулаарч шөнөдөө 6-11 градус хүйтэн, өдөртөө 3-8 градус дулаан байна. 4-нөөс хоёрдугаар арав хоногийн эх хүртэл мөн хоёрдугаар арав хоногийн сүүлчээр хүйтэрч Орхон, Эг, Туул голын хөндийгөөр шөнөдөө 27-32 градус, өдөртөө 13-18 градус хүйтэн, бусад нутгаар шөнөдөө 20-25 градус, өдөртөө 8-13 градус хүйтэн байна. Сарын дунд үеэр Эг, Орхон, Туул голын хөндийгөөр шөнөдөө 21-26 градус, өдөртөө 8-13 градус хүйтэн, бусад нутгаар шөнөдөө 15-20 градус, өдөртөө 1-6 градус хүйтэн байна. Бусад хугацаанд шөнөдөө 10-15 градус хүйтэн, өдөртөө 1 градус хүйтнээс 4 градус дулаан байна.

3-нд ихэнх нутгаар, хоёрдугаар арав хоногийн эхэн болон сүүлчээр зарим газраар цас, 24-26-нд нутгийн хойд хэсгээр, сарын сүүлээр зарим газраар хур тунадас, уулаараа нойтон цас орох төлөвтэй. Салхи нэгдүгээр арав хоногийн эхэн ба сүүлчээр зарим газраар 16-18м/с, хоёрдугаар арав хоногийн эхэн ба сүүлчээр нутгийн өмнөд хэсгээр, 24-26-нд зарим газраар 12-14 м/с зарим үед 18-20м/с хүртэл ширүүсч цасан ба шороон шуурга шуурах төлөвтэй.

**Дөрөвдүгээр сард.** Энэ сарын агаарын дундаж температур 2-7 градус дулаан буюу Баян-Агт, Сайхан сумын баруун хэсгээр олон жилийн дунджаас 0.5-1.0 градусаар дулаан, бусад нутгаар олон жилийн дунджийн орчим байна. Энэ сард нутгийн хойд хэсгээр олон жилийн дунджаас ахиу, бусад нутгаар дунджийн орчим хур тунадас орох төлөвтэй.

Зураг 1.6

2-р сарын агаарын температурын хоногийн явц



Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлд хэрхэн нөлөөлөх талаар

3 дугаар сарын цаг агаарын урьдчилсан мэдээгээр агаарын дундаж температур ихэнх нутгаар олон жилийн дунджаас 0.5-1.0 градусаар дулаан, дунджаас ахиу хур тунадас орохоор байна.

2 дугаар сарын 20-ны байдлаар Могод, Гурванбулаг, Сайханд харагдах орчны 90%-д цастай байгаагаас цасны зузаан дунджаар 3-5 см байгаа бол Тэшигт дунджаар 17 см, Рашаантад 12 см, Дашинчилэн, Баяннуурт 12 см, Бугатад 11 см зузаан буюу нягт нь 0.11-0.21 гр/см<sup>3</sup>, Хангал, Хишиг-Өндөрт 9 см, Хутагт 7 см, Орхон, Булганд 6 см, Баян-Агт, Сайханд 5 см зузаан, нягт нь 0.12-0.23 гр/см<sup>3</sup> битүү цастай байна.

Цаашид 3 дугаар сард үе үе цасан болон шороон шуурга шуурч мал төллүүлэх, малын бэлчээрлэлтэнд таагүй нөлөөлж болзошгүйг онцгой анхаарна уу.




## 1.5 Гэмт хэрэг

Аймгийн хэмжээнд 2016 оны 1 сарын байдлаар 32 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өнгөрсөн оны мөн үеийнхээс 10 хэргээр буюу 45.5 хувиар өссөн байна. БҮСТЗЭТХэрэг 11 бүртгэгдэн 4 хэргийг илрүүлж, гэмт хэргийн илрүүлэлт 36,4 хувьтай байгаа нь өнгөрсөн оны мөн үеийнхээс 13.6 хувиар буурсан байна. Гэмт хэргийн гаралт Баян-Агт, Хутаг-Өндөр, Хангал, Орхон, Булган, Могод сумдад гэмт хэргийн гаралт урьд оны мөн үеийнхээс өсч, Бугат, Рашаант, Бүрэгхангай, сумдад урьд оны мөн үеийнхтэй ижил түвшинд, бусад сумдад гэмт хэргийн гаралт өнгөрсөн оны мөн үеийнхээс буурсан байна.

Зураг 1.7

Бүртгэгдсэн гэмт хэрэг, жил бүрийн эхний 2 сарын байдлаар




Хэргийн өнгөөр нь авч үзвэл

- ИЭЧЭМЭГХ 21 бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеийнхээс 4 хэргээр буюу 16 хувиар
  - Хулгайн гэмт хэрэг 19 бүртгэгдсэн өмнөх оны мөн үеийнхээс 4 хэргээр буюу 17,4 хувиар, үүнээс мал хулгайлах хэрэг 8 бүртгэгдэн өмнөх оны мөн үеийнхээс 10 хэргээр буюу 55,6 хувиар буурчээ.
  - Хүнийг санаатай алах гэмт хэрэг 4 бүртгэгдэн өмнөх оны мөн үеийнхээс 100 хувиар
  - Хүчиндэх гэмт хэрэг 2 бүртгэгдэн урьд оны мөн үеийнхээс 100 хувиар
  - ХАБАЖЭГХ 4 бүртгэгдэж өмнөх оны мөн үеийнхээс 1 хэргээр буюу 33,3 хувиар
  - Албан тушаалын эсрэг гэмт хэрэг 2 бүртгэгдсэн өмнөх оны мөн үеийнхээс 100 хувиар тус тус өсчээ.
  - Танхайрах гэмт хэрэг 1 бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеийнхтэй ижил түвшинд
- Гэмт хэргийн улмаас учирсан хохирол  
Гэмт хэргийн улсаас нийт иргэд, аж ахуй нэгж байгууллагад 144,6 сая төгрөгний хохирол

учирснаас иргэдэд 144 сая төгрөгний хохирол учирсан байна. Үүнээс бүртгэлд мөрдөн байцаалтын шатанд 87,4 сая төгрөгний хохирлыг нөхөн төлүүлж ажилласан .

Зураг 1.8


Гэмт хэргийн улмаас учирсан хохирол, жил бүрийн эхний 2 сарын байдлаар, сая төг



Гэмт хэргийн улмаас 13 хүн нас барсан ба өнгөрсөн оны мөн үеийнхээс 40 хувиар өссөн байна. Бусдыг амиа хорлоход хүргэх гэмт хэргийн улмаас 4, бусдыг болгоомжгүй алах гэмт хэргийн улмаас 1 ХАБАЖЭГХ – ийн улмаас 4 иргэн тустус амь насаа алдсан байна. Гэмт хэргийн улмаас 28 хүн гэмтсэн нь ИЭЧЭМЭГХ –ын улмаас 21, ХАБАЖЭГХ –ийн улмаас 5 хүн ,бусад хэргийн оны мөн үеийнхээс 3 буюу 12 хувиар өссөн байна. улмаас 2 хүн гэмтсэн нь өмнөх оны мөн үеийнхээс 3 буюу 12 хувиар өссөн байна.

Зураг 1.9

Гэмт хэргийн улмаас гэмтсэн, нас барсан хүн, жил бүрийн эхний 2 сарын байдлаар



2016 оны эхний 2 сарын байдлаар гудамж талбайд хэвийн бус явж орон гэртээ агсан согтуу тавьсны улмаас 106 хүн эрүүлжүүлэгдсэн нь өмнөх оны мөн үеийхээс 5 хүнээр буюу 5 хувиар буурсан бол , захиргааны журмаар 4 хүнийг баривчилж

шийтгэл эдлүүлсэн нь өмнөх оны мөн үеийнхээс 3 хүнээр буюу 84,6 хувиар буурсан үзүүлэлттэй байна . Согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодож эрхээ хасуулж торгуулсан 63 иргэн байна.



## II.Эдийн засгийн үзүүлэлт


### II.1 Аймгийн төсөв

Аймгийн орон нутгийн төсвийн нийт орлого 2016 оны эхний 2 сарын байдлаар 7720.1 сая төгрөг, зарлага 6653.3 сая төгрөг болж, аймгийн төсвийн нийт тэнцэл 1066.7 сая төгрөгний эерэг гарлаа.

Орон нутгийн төсвийн орлогын 36 хувийг татварын орлого, 1 хувийг татварын бус орлого, 63 хувийг улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг эзэлж байна. Аймгийн төсвийн зарлагын хэмжээ 2016 оны эхний 2 сард 6653.3 сая.төг болоход 79 хувийг бараа материалын зардал, 18 хувийг урсгал шилжүүлгийн зардал эзэлж байна.

Зураг II.1


Аймгийн төсвийн орлого, зарлага 2016 оны 2-р сарын байдлаар, сая төг



Нийт авлага 4.6 сая, өглөг 663.9 сая төгрөг байна. Нийт өглөгөөс цалин, НДШ-ийн өр 118.7сая төг, халаалт, гэрэл цахилгаан, цэвэр бохир усны өр 380.4 сая, эмийн өр 2.6 сая, бусад зардлын өглөг 162.2 сая төгрөг байна.

Зураг II.2

Аймгийн төсвийн өр, авлага сараар



Орон сууц, ус, цахилгаан, түлш	12.3	105.9	101.9	100.0
Гэр ахуйн тавилга, бараа	4.7	102.6	100.0	100.0
Эм тариа, эмнэлэгийн үйлчилгээ	3.6	99.2	100.0	100.0
Тээвэр	12.2	102.3	98.7	98.7
Холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээ	4.4	99.9	100.0	100.0
Амралт, чөлөөлт цаг, соёлын бараа, үйлчилгээ	2.8	99.9	100.0	100.0
Боловсролын үйлчилгээ	4.7	132.5	100.0	100.0
Зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээ	2.6	107.9	100.0	100.0
Бусад бараа, үйлчилгээ	4.1	103.9	101.1	100.0




## II.2 Үнэ

### Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнийн индекс аймгийн хэмжээнд 2016 оны 2 дугаар сард өмнөх сарынхаас 0.4 хувиар өссөн, оны эхнээс 0.4 хувиар, өмнөх оны мөн үеийнхээс 1.5 хувиар өслөө.

Зураг II.3

Хэрэглээний үнийн аймгийн индекс (суурь үе буюу 2010-XII=100хувь)



Хүснэгт II.1

Хэрэглээний үнийн аймгийн индекс (суурь үе буюу 2010-XII=100хувь)

Бараа, үйлчилгээний бүлэг	Жин	2016 II 2015 II	2016 II 2015 XII	2016 II 2016 I
Ерөнхий индекс	100.0	101.5	100.7	99.6
Хүнсний бараа, ундаа, ус	29.3	99.8	101.9	99.8
Согтууруулах ундаа, тамхи	3.2	101.8	100.2	99.9
Хувцас, бөс, бараа, гутал	16.1	96.8	101.0	99.4

Зураг II.4

Хэрэглээний бараа үйлчилгээний үнийн индекс, хувь, 2015 оны I-XII сар 2016 оны I-II сар, (өмнөх сар=100%)



### Хөдөө аж ахуйн зарим бүтээгдэхүүний зах зээлийн дундаж үнэ

Мал аж ахуйн бүтээгдэхүүний зах зээлийн үнийн судалгаагаар 2016 оны эхний 2 сард адууны шир 20.0 мян.төгрөг, үхрийн 1.8-2.3 м урттай шир 16.2 мян.төгрөг, 2.3 м-с дээш урттай шир 23.7 мян.төгрөг, хонины нэхий 0.5 мян.төгрөг, ямааны арьс 7.1 мян.төгрөг байна. Өмнөх оны мөн үеийнхээс адууны шир 33.3 хувиар, үхрийн 1.8-2.3 метрийн урттай шир 59.3 хувиар, 2.3 метрийн урттай шир 60.4 хувиар буурсан байна.

Малын дундаж үнэ: 2016 оны 2 сард тэмээ 883 мян.төг, адуу 650 мян.төг, үхэр 863 мян.төг, хонь 123 мян.төг, ямаа 88 мян.төг болж буюу өмнөх оны мөн үеийнхээс тэмээ 10.8 хувиар, адуу 17.2 хувиар, үхэр 18.6 хувиар, хонь 23.1 хувиар, ямаа 16.2 хувиар тус тус буурчээ



## II.5 Аж үйлдвэр

Аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл 2016 оны эхний 2 сард 531.4 сая.төг болж, өмнөх оны мөн үеийнхээс 118.1 сая.төг буюу 22.5 хувиар буурсан байна. Үүнд боловсруулах аж үйлдвэрийн үйлдвэрлэл 76.1 сая.төг буюу 27.5 хувь, цахилгаан дулаан, эрчим хүч үйлдвэрлэл 72.2 буюу 29.9 хувиар буурсан нь нөлөөлсөн бол уул уурхай, олборлох үйлдвэрийн нийт үйлдвэрлэл 160.7 сая. төг болж, өмнөх оны мөн үеийнхээс 30.3 сая.төг буюу 23.2 хувиар өссөн байна.

Хүснэгт II.2

Аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл, жил бүрийн эхний 2 сарын байдлаар, сая төг

Аж үйлдвэрийн салбар	2015 II	2016 II	2016 II 2015 II
Нийт дүн	649.4	531.4	81.8
Уул уурхай, олборлох аж үйлдвэр	130.4	160.7	123.2
Боловсруулах аж үйлдвэр	276.8	200.7	72.5
Цахилгаан, дулааны эрчим хүч үйлдвэрлэл, усан хангамж	242.2	170	70.1

Аж үйлдвэрийн салбар нь 2016 оны эхний сард 919,6 сая төгрөгний бүтээгдэхүүн борлуулсан нь өмнөх оны мөн үеийнхтэй ижил түвшинд байна. Нийт борлуулалтын 180.1 сая төгрөг буюу 39.2 хувийг уул уурхай салбар 270 сая төгрөг буюу 11.5 хувийг боловсруулах аж үйлдвэрийн салбар, 426 сая төгрөг буюу 45.3 хувийг цахилгаан дулааны үйлдвэрлэлт эзэлж байна.

Зураг II.5

Аж үйлдвэрийн салбарын борлуулалт жил бүрийн эхний 2 сарын байдлаар



## II.6 Хөдөө аж ахуй

### Зүй бусын хорогдол

Том малын зүй бусын хорогдол 2016 оны эхний 2 сард 11.6 мян. толгой болж, өмнөх оны мөн үеийнхээс 9.9 мян.толгой мал буюу 7 дахин хувиар өссөн байна. Нийт хорогдлыг малын төрлөөр авч үзвэл адуу 1 мянга буюу 9 хувь, үхэр 1.5 мянга буюу 13 хувь, хонь 4.5 мянга буюу 38 хувь, ямаа 1.5 мянга буюу 40 хувийг тус тус хорогдоод байна. Нийт хорогдлын дийлэнх хувийг ямаа, хонь эзэлж байна. Хорогдлыг сумаар авч үзвэл Баяннуур сум 20.2 хувийг, Рашаант сум 17.4 хувийг, Дашинчилэн сум 14.2 хувь, Гурванбулаг сум 10.6 хувийг тус тус эзэлж байгаа нь дийлэнх болж байна. Өвчнөөр хорогдсон мал 107 болж өмнөх оны мөн үеийнхээс 19 толгой буюу 15.7 хувиар буурсан байна.


Зураг II.6

Зүй бусаар хорогдсон том мал, сумаар, эхний 2 сарын байдлаар, толгой



Зураг II.7

Том малын зүй бусын хорогдол



## ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД, жил бүрийн эхний 2-р сарын байдлаар

Үзүүлэлтүүд	2014 I-II	2015 I-II	2016 I-II	2016 I-II 2015 I-II
<b>Нийгмийн статистикийн үзүүлэлтүүд</b>				
Төрсөн хүүхэд	179	183	145	79
Бүртгэлтэй ажилгүй иргэд 2 дугаар сарын эцэст	750	744	573	77
Халдварт өвчнөөр өвчлөгсөд	86	54	76	140
Бүртгэгдсэн гэмт хэрэг	57	60	61	101
Нийгмийн даатгалийн орлого	1366.2	1539	1801.5	117
Нийгмийн даатгалийн зарлага	3456.6	4236.3	4835.9	114
<b>Макро эдийн засгийн үзүүлэлтүүд</b>				
Орон нутгийн төсвийн орлого, сая.төг	-	-	7720.1	-
Орон нутгийн төсвийн зарлага, сая.төг	-	-	6653.3	-
Адууны дундаж үнэ /нас гүйцсэн/	-	990	883	89
Үхэрийн дундаж үнэ /нас гүйцсэн/	-	785	650	82
Тэмээний дундаж үнэ /нас гүйцсэн/	-	1060	863	81
Хониний дундаж үнэ /нас гүйцсэн/	-	160	123.1	76
Ямааны дундаж үнэ /нас гүйцсэн/	-	105	88	84
<b>Эдийн засгийн статистикийн үзүүлэлтүүд</b>				
Аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл, жил бүрийн 2-р сарын байдлаар, сая.төг	-	649.4	531.4	81
-Уул уурхай, олборлох аж үйлдвэр	-	130.4	160.7	123
-Боловсруулах аж үйлдвэр	-	276.8	200.7	72
-Цахилгаан, дулааны эрчим хүч, усан хангамж	-	242.2	170	70

## I.1 ХӨДӨЛМӨР

Үзүүлэлт	2015 I-II		2016 I-II		$\frac{2016 \text{ I-II}}{2015 \text{ I-II}}$	
	Бүгд	эмэгтэй	Бүгд	эмэгтэй	Бүгд	эмэгтэй
Ажил хайгч иргэн /сарын эхэнд/	744	349	573	263	77.0	75.4
Тайлант хугацаанд нэмэгдсэн иргэн	142	78	120	68	84.5	87.2
Тайлант хугацаанд хасагдсан иргэн /идвэхгүйн улмаас/	210	94	251	118	119.5	125.5
Ажил хайгч иргэн /сарын эцэст/	676	333	442	213	65.4	64.0
Ажилд зуучлагдан орсон иргэн /салбараар/	24	8	6	2	25.0	25.0
Хувьцаат компани	-	-	-	-	-	-
Хязгаарлагдмал хариуцлагатай компани	16	5	2	1	12.5	20.0
Нөхөрлөл, хоршоо	-	-	-	-	-	-
Төрийн өмчит үйлдвэрийн газар	-	-	-	-	-	-
Орон нутгийн өмчит үйлдвэрийн газар	-	-	-	-	-	-
Төсөвт байгууллага	2	-	1	1	50.0	-
Төрийн бус байгууллага	-	-	-	-	-	-
Сан	-	-	-	-	-	-
Бусад	6	3	3	-	50.0	-
Ажил хайгч иргэн (насны бүлгээр)	744	349	442	213	59.4	61.0
15-24	135	72	57	32	42.2	44.4
25-34	213	103	153	69	71.8	67.0
35-44	177	85	135	71	76.3	83.5
45-54	181	79	75	35	41.4	44.3
55-59	30	9	18	5	60.0	55.6
60+	8	1	4	1	50.0	100.0
Ажил хайгч иргэн (боловсролын түвшнээр)	744	349	442	213	59.4	61.0
Магистр, доктор	3	2	1	1	33.3	50.0
дипломын болон бакалаврын дээд	114	71	93	66	81.6	93.0
тусгай мэргэжлийн дунд	26	16	17	11	65.4	68.8
техникийн болон мэргэжлийн	47	19	38	16	80.9	84.2
бүрэн дунд	375	179	232	98	61.9	54.7
суурь	140	50	40	18	28.6	36.0
бага	31	11	14	3	45.2	27.3
боловсролгүй	8	1	7	0	87.5	-

## I.2 НИЙГМИЙН ДААТГАЛ

Үзүүлэлтүүд	2014 I-II	2015 I-II	2016 I-II	2016 I-II 2015 I-II
Нийгмийн даатгалын сангийн орлого, сая.төг	1366.2	1539	1801.5	117.1
Үүнээс:				
Тэтгэврийн даатгалын сан	889.9	998.8	989.1	99.0
Тэтгэмжийн даатгалын сан	101.7	114.8	154.9	134.9
Эрүүл мэндийн даатгалын сан	285.5	326.7	517.5	158.4
ҮОМШӨ*-ний даатгалын сан	69.5	71.6	93.7	130.9
Ажилгүйдлийн даатгалын сан	19.6	27.1	46.3	170.8
Нийгмийн даатгалын сангийн зарлага, сая.төг	3456.5	4236.3	4835.9	114.2
Үүнээс:				
Тэтгэврийн даатгалын сан	2995.6	3742.9	4326.7	115.6
Тэтгэмжийн даатгалын сан	117.3	176.2	130.2	73.9
Эрүүл мэндийн даатгалын сан	291.7	257.1	304	118.2
ҮОМШӨ*-ний даатгалын сан	32	32.8	37.7	114.9
Ажилгүйдлийн даатгалын сан	19.9	27.3	37.3	136.6

## I.3 ЭРҮҮЛ МЭНД

Аймгийн хэмжээнд гарсан халдварт өвчин, өвчний төрлөөр жил бүрийн 2-р сарын байдлаар

Үзүүлэлт	2015 I-II	2016 I-II	2016/2015
Амаржсан эхийн тоо	184	144	78%
Амьд төрсөн хүүхэд	183	145	79%
Эхийн эндэгдэл	-	-	0%
Амьгүй төрөлт	3	1	0%
Гэрийн төрөлт	-	1	100%
Нэг хүртэл насандаа эндсэн хүүхэд	3	1	33%
Перинаталь эндэгдэл	5	2	40%
Амьд төрсөн 1000 хүүхэд тутмаас 1 хүртэл насанд эндсэн хүүхэд	16.4	6.9	42%

Аймгийн хэмжээнд гарсан халдварт өвчин, өвчний төрлөөр, жил бүрийн 2-р сарын байдлаар

Үзүүлэлт	2015 I-II	2016 I-II	2016/2015
Нийт гарсан халдварт өвчин	54	76	141%
Гэдэсний халдварт өвчин	3	0	0%
Амьсгалын замын халдварт өвчин	21	34	162%
Байгалын голомтот халдварт өвчин	0	0	0%
Бэлэгсийн замаар дамжих халдварт өвчин	24	34	142%
Арьсны халдварт өвчин	6	8	133%

## I.4 ГЭМТ ХЭРЭГ

Бүртгээгдсэн гэмт хэрэг, жил бүрийн 2-р сарын байдлаар

Сум	2012 I-II	2013 I-II	2014 I-II	2015 I-II	2016 I-II	2016 I-II / 2015 I-II
Булган	15	21	15	22	21	95.4
Баян-Агт	3	2	0	1	1	100
Баяннуур	0	0	1	2	1	50
Бугат	2	3	5	5	3	60
Бүрэгхангай	3	4	4	7	5	71.4
Гурванбулаг	1	0	6	4	3	75
Дашинчилэн	0	3	1	4	3	75
Могод	1	6	0	2	6	300
Орхон	2	7	2	5	7	140
Рашаант	3	3	3	1	2	200
Сайхан	1	1	5	1	1	100
Сэлэнгэ	4	2	2	2	1	50.0
Тэшиг	1	2	2	0	1	
Хангал	2	1	3	0	1	
Хишиг- Өндөр	2	8	3	2	2	100
Хялганат	1	2	0	1	1	100
Хутаг-Өндөр	2	5	5	1	2	200
Бүгд	43	70	57	60	61	101.6

Хулгайн гэмт хэрэг, сумаар, жил бүрийн 2-р сарын байдлаар

Сум	2012 I-II	2013 I-II	2014 I-II	2015 I-II	2016 I-II
Булган	11	10	4	4	6
Баян-Агт	2	2	0	0	0
Баяннуур	0	0	1	2	0
Бугат	1	1	2	2	2
Бүрэгхангай	2	2	1	5	1
Гурванбулаг	1	0	4	1	0
Дашинчилэн	0	2	0	4	2
Могод	1	5	0	0	2
Орхон	1	6	0	4	3
Рашаант	0	2	3	1	1
Сайхан	0	0	4	0	1
Сэлэнгэ	2	1	2	0	0
Тэшиг	0	1	0	0	0
Хангал	1	0	1	0	0
Хишиг-Өндөр	0	5	3	0	1
Хутаг-Өндөр	1	4	1	0	0
Хялганат	0	1	0	0	0
Бүгд	23	27	20	6	9

## Сумдын хэргийн илрүүлэлт 2016 оны эхний 2 сарын байдлаар

Сум	Бүртгэгдэх үедээ сэжигтэн этгээд нь тогтоогдоогүй хэрэг	Илрээгүй хэрэг	Яллагдагчаар татаж ял сонгосон хэрэг	Хэргийн илрүүлэлтийн хувь
Булган	5	3	2	40%
Баян-Агт				
Баяннуур				
Бугат	2	1	1	50%
Бүрэгхангай	1		1	100%
Гурванбулаг				
Дашинчилэн	2	2	0	100%
Могод	2	1	1	50%
Орхон	5	3	2	40%
Рашаант				
Сайхан	1		1	100%
Сэлэнгэ				
Тэшиг	1		1	100%
Хангал				
Хишиг-Өндөр	1		1	100%
Хутаг-Өндөр				
Хялганат				
Бүгд	20	10	10	50%

## Гэмт хэргийн улмаас учирсан хохирол, жил бүрийн 2-р сарын байдлаар

Үзүүлэлт	2012 I-II	2013 I-II	2014 I-II	2015 I-II	2016 I-II	2016-II % 2015-II
	сая төгрөг					
Учирсан хохирол- Бүгд	686.0	766.0	1326	1450	1448.0	99.9
Үүнээс						
Нөхөн төлүүлсэн	119	205.2	894.0	743.0	846	113.9
Нөхөн төлүүлэлтийн хувь	17.3	26.8	67.4	51.2	58.4	114.0

## II.2 ҮНЭ

## Хэрэглээний үнийн ерөнхий индекс, барааны бүлгээр

Бараа, үйлчилгээний бүлгийн нэр	2016 II 2015 II	2016 II 2015 XII	2016 II 2016 I
Ерөнхий индекс	101.5	100.7	99.6
Хүнсний бараа, ундаа, ус	99.8	101.9	99.8
Согтууруулах ундаа, тамхи	101.8	100.2	99.9
Хувцас, бөс бараа гутал	96.8	101.0	99.4
Орон сууц, ус цахилгаан, түлш	105.9	101.9	100.0
Гэр ахуйн тавилга, гэр ахуйн бараа	102.6	100.0	100.0
Эм тариа, эмнэлгийн үйлчилгээ	99.2	100.0	100.0
Тээвэр	102.3	98.7	98.7
Холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээ	99.9	100.0	100.0
Амралт, чөлөөт цаг, соёлын бараа, үйлчилгээ	99.9	100.0	100.0
Боловсролын үйлчилгээ	132.5	100.0	100.0
Зочид буудал, нийтийн хоол, дотуур байр	107.9	100.0	100.0
Бусад бараа, үйлчилгээ	103.9	101.1	100.0

Хүнсний гол нэр төрлийн барааны 7 хоногийн ажиглалт 2015 оны 2-р сарын сүүлийн 7 хоног, 2016 оны 2-р сарын сүүлийн 7 хоногтой харьцуулсан

Барааны нэр төрөл	2015 II/24	2016 II/23	16 II /23 15 II/24
"Алтан тариа" дээд, савласан	1500	1500	100.0
гурил I зэрэг, задгай	960	1200	125
Орон нутгийн "Хангай" 1-р	880	910	103.4
гурил "Орхон мандал"	800	950	118.8
1-р гурил	800	950	118.8
Талх "Ундрах" аймгийн үйлвэр	900	1000	111.1
Цагаан будаа	2400	2500	104.2
Элсэн чихэр	1800	1800	100
Сүү Задгай	1500	2000	133.3
"Цэвэр сүү"	2750	2700	98.2
Ургамлын тос, "Кларина"	3600	3600	100
Мах Үхрийн	7000	5500	78.6
Хонины	5500	4500	81.8
Адууны	5500	4000	72.7
Ямааны	4500	3500	77.8
Төмс /монгол/	1200	1000	83.3
Лууван /монгол/	1000	2000	200
Байцаа /хятад/	1000	1000	100
Ногоо Манжин /монгол/	1500	2000	133.3
Сонгино /монгол/	2500	2500	100
Сонгино /хятад/	1500	1500	100
Сармис	300	350	116.7


## Хүнсний гол нэр төрлийн барааны ажиглалт, жил бүрийн 2-р сарын байдлаар

Барааны нэр төрөл		Хэмжих нэгж	2012 II	2013 II	2014 II	2015 II	2016 II	2016 II / 2015 II
"Алтан тариа"	I зэрэг	кг	950	1000	1200	1400	1283	91.6
гурил /задгай/	II зэрэг	кг	700	700	700	900	1000	111.1
Будаа	Цагаан	кг	1800	1800	2300	2400	2466	102.8
	Шар	кг	1500	1500	1700	1900	1900	100.0
Элсэн чихэр		кг	1800	1800	1800	1700	1666	98.0
Хонины мах	ястай	кг	5500	7000	6000	5500	4000	72.7
	цул	кг	5500	7000	6000	5500	4000	72.7
Үхрийн мах	ястай	кг	6000	7000	7000	7000	5500	78.6
	цул	кг	6000	7000	7000	7000	5500	78.6
Адууны мах		кг	4500	5500	6000	5500	4000	72.7
Ямааны мах		кг	4500	4500	4500	4500	3500	77.8
Сүү	задгай	л	1500	1500	1500	2000	2000	100.0
	"Цэвэр сүү"	л	1800	1800	2300	2750	2633	95.7
Байцаа	монгол	кг	900	1200	1000	1000	1000	100.0
Лууван	монгол	кг	800	1000	1000	1000	1800	180.0
Манжин	монгол	кг	800	1000	1500	1500	2000	133.3
Төмс	монгол	кг	800	800	800	1200	1000	83.3
Сонгино	хятад	кг	1000	1500	1500	1500	1500	100.0
Сармис, булцуу		кг	300	300	300	300	350	116.7
Ургамлын тос		л	3000	3000	3500	3600	3566	99.1
Өндөг		ш	250	250	420	350	300	85.7
Талх "Ундрах" орон нутгийн		ш	650	650	750	900	1066	118.4


## Нэг литр шатахууны үнэ, 2016 оны 2-р сарын байдлаар

ШТС	АИ 95	АИ 92	АИ 80	Дизиль түлш	Газ
Шунхлай	0	1590	1480	1690	0
Тэс	0	1580	1470	1680	0
Магнай трейд	0	1590	1480	1690	0
Жаст ойл	0	1590	1480	1690	0
Петровис	1760	1590	1480	1690	0
Газ	0	0	0	1690	1100


## Нэг кг хүнсний ногооны дундаж үнэ, жил бүрийн 2-р сарын байдлаар



Нэг кг хонины махны үнэ, төгрөг



Нэг кг үхрийн махны үнэ, төгрөг



Малын гаралтай бүтээгдэхүүний зах зээлийн дундаж үнэ, сараар, төгрөгөөр

№	Бүтээгдэхүүний нэр	Хэмжих нэгж	2015 II	2016 II
1	Гахайн мах	кг	-	6000
2	Тахиан мах	кг	-	3000
3	Цагаан ноолуур	кг	47500	-
4	Бор ноолуур	кг	47500	-
5	Адууны шир	ш	30000	20000
6	Үхрийн шир 1.8-2.3 метрийн хэмжээтэй шир	ш	40000	16250
7	Үхрийн шир 2.3 метрээс дээш хэмжээтэй шир	ш	60000	23750
8	Хонины ноостой нэхий	ш	5000	500
9	Ямааны арьс	ш	20000	7125

Малын зах зээлийн дундаж үнэ, жил бүрийн 2-р сарын байдлаар, мян төгрөгөөр

№	Бүтээгдэхүүний нэр	2015 II	2016 II
1	<b>Буур</b>	967	975
2	Нас гүйцсэн ат	990	883
3	Нас гүйцсэн ингэ	805	760
4	Эр шилбэ	634	488
5	Эм шилбэ	582	488
6	Эр ботго	225	170
7	Эм ботго	225	170
8	<b>Азарга</b>	1037	1075
9	Соёолон үрээ	785	650
10	Соёолон гүү	751	608
11	Шүдлэн үрээ	526	410
12	Шүдлэн байдас	522	395
13	Эр унага	205	168
14	Эм унага	207	170
15	<b>Бух</b>	1128	1042

16	Хязаалан шар	1060	863
17	Хязаалан дөнж	899	715.6
18	Шүдлэн эр үхэр	686	519
19	Шүдлэн гунж	682	497
20	Эр тугал	232	184
21	Эм тугал	232	184
22	<b>Хуц</b>	177	166
23	Эр хонь	160	123.1
24	Эм хонь	117	90
25	Эр төлөг	86	57
26	Эм төлөг	85	56
27	Эр хурга	47	30
28	Эм хурга	47	30
29	<b>Ухна</b>	133	190
30	Эр ямаа	105	88
31	Эм ямаа	82	65
32	Эр борлон	54	41
33	Эм борлон	54	40
34	Эр ишиг	34	23
35	Эм ишиг	35	23

Адууны үнэ, сумаар, мян.төг, жил бүрийн 2-р сарын байдлаар

Сумын нэр	Нас гүйцсэн адуу				Өсвөр насны адуу			
	Морь		Гүү		Эр		Эм	
	2015 II	2016 II	2015 II	2016 II	2015 II	2016 II	2015 II	2016 II
Булган	767	700	766	700	458	500	458	500
Баян-Агт	610	-	566	-	440	400	448	400
Баяннуур	936	700	890	600	572	350	561	350
Бугат	790	800	778	800	568	650	580	350
Бүрэгхангай	725	700	725	700	458	550	458	550
Гурван булаг	738	600	725	-	556	-	562	-
Дашинчилэн	658	550	589	450	465	350	460	300
Могод	825	700	766	700	441	300	383	300
Орхон	725	600	716	550	483	350	483	350
Рашаант	629	550	550	500	351	370	337	350
Сайхан	675	600	658	450	384	300	365	300
Сэлэнгэ	900	500	766	500	641	300	654	350
Тэшиг	730	550	740	550	461	400	479	400
Хангал	948	800	843	750	595	450	595	450
Хишиг-өндөр	716	550	708	460	446	430	458	220
Хутаг-Өндөр	870	850	887	800	595	450	595	450

## Тэмээний үнэ, сумаар, мян.төг жил бүрийн 2-р сарын байдлаар

Сумын нэр	Нас гүйцсэн тэмээ				Өсвөр насны тэмээ			
	Ат		Ингэ		Эр		Эм	
	2015 II	2016 II	2015 II	2016 II	2015 II	2016 II	2015 II	2016 II
Баяннуур	1409	1000	1000	800	545	400	545	400
Бүрэгхангай	1025	900	900	800	495	700	495	700
Гурванбулаг	1120	800	800	600	600	-	600	-
Дашинчилэн	925	700	700	800	577	400	518	400
Могод	891	900	900	800	442	450	367	400
Сайхан	1172	1000	1000	800	710	-	660	-

## Үхрийн үнэ, сумаар, мян.төг, жил бүрийн 2-р сарын байдлаар

Сумын нэр	Нас гүйцсэн үхэр				Өсвөр насны үхэр			
	Эр		Эм		Эр		Эм	
	2015 II	2016 II	2015 II	2016 II	2015 II	2016 II	2015 II	2016 II
Булган	925	900	1000	850	800	700	800	650
Баян-Агт	1320	800	1000	700	750	500	750	500
Баяннуур	1418	600	1000	500	800	500	800	400
Бугат	1204	1000	1200	950	700	600	750	600
Бүрэгхангай	845	800	800	700	600	550	600	-
Гурван булаг	975	800	900	400	800	600	800	400
Дашинчилэн	862	700	850	550	750	520	720	-
Могод	1195	800	1000	700	500	500	500	500
Орхон	1200	600	900	550	600	500	600	500
Рашаант	1029	1100	700	750	500	700	450	600
Сайхан	1045	800	1000	700	650	450	650	450
Сэлэнгэ	1466	1300	1200	1000	900	400	900	450
Тэшиг	1041	700	800	600	650	450	700	450
Хангал	916	700	1000	700	600	500	600	500
Хишиг-өндөр	1066	700	900	500	760	450	700	400
Хутаг-Өндөр	1320	900	750	900	500	500	500	500

## Хонь, ямааны үнэ, сумаар, мян.төг жил бүрийн 2-р сарын байдлаар

Сумын нэр	Нас гүйцсэн хонины үнэ				Нас гүйцсэн ямааны үнэ			
	Эр		Эм		Эр		Эм	
	2015 I	2016 I	2015 I	2016 I	2015 I	2016 I	2015 I	2016 I
Булган	135	100	120	90	100	90	80	80
Баян-Агт	175	120	160	80	140	80	60	90
Баяннуур	154	80	100	45	100	60	30	80
Бугат	170	160	140	140	120	120	100	120
Бүрэгхангай	110	100	120	90	100	90	70	80
Гурван булаг	134	150	90	80	60	100	60	60
Дашинчилэн	123	90	90	55	120	70	35	70
Могод	151	150	140	80	120	80	80	100

Орхон	161	100	130	80	130	90	80	100
Рашаант	130	120	100	55	90	120	55	60
Сайхан	123	100	90	80	75	80	50	50
Сэлэнгэ	150	100	150	120	120	90	80	100
Тэшиг	174	150	120	80	120	80	70	90
Хангал	185	150	150	100	200	80	70	150
Хишиг-өндөр	160	150	118	70	138	90	50	88
Хутаг-Өндөр	152	100	120	100	100	90	90	80

## II.6 МАЛ АЖ АХУЙ

*Зүй бусаар хорогдсон том мал, төрлөөр, жил бүрийн эхний 2 сарын байдлаар*

Малын төрөл	Хорогдсон том мал				Оны эхний малд том малын хорогдлын эзлэх хувь			
	2015		2016		2015		2016	
	I	II	I	II	I	II	I	II
Бүгд	819	1645	3676	11633	0.03	0.05	0.11	0.36
Адуу	165	281	264	1015	0.07	0.11	0.10	0.38
Үхэр	131	214	324	1511	0.05	0.08	0.12	0.54
Тэмээ	0	1	0	0	0.00	0.08	0.00	0.00
Хонь	278	608	1495	4475	0.02	0.04	0.09	0.26
Ямаа	245	541	1593	4632	0.03	0.06	0.16	0.47

*Зүй бусаар хорогдсон том мал, сумаар, 2016 оны 2-р сарын байдлаар*

Сум	Хорогдсон том мал						Оны эхний малд эзлэх хувь					
	Бүгд	Адуу	Үхэр	Тэмээ	Хонь	Ямаа	Бүгд	Адуу	Үхэр	Тэмээ	Хонь	Ямаа
Булган	15	1	2	0	7	5	0	0	0	0	0	0
Баян-Агт	264	64	51	0	79	70	0.1	0.4	0.3	0	0.1	0.1
Баяннуур	2352	158	396	0	713	1085	1.9	2	3.8	0	1.2	2.4
Бугат	96	17	15	0	18	46	0.1	0.2	0.1	0	0	0.2
Бүрэгхангай	185	18	24	0	48	95	0.1	0.1	0.1	0	0	0.1
Гурван булаг	1232	53	75	0	631	473	0.4	0.2	0.5	0	0.3	0.4
Дашинчилэн	1651	114	278	0	591	668	0.7	0.6	1.7	0	0.5	0.9
Могод	702	95	102	0	225	280	0.2	0.3	0.5	0	0.1	0.4
Орхон	528	76	42	0	220	190	0.2	0.3	0.2	0	0.2	0.2
Рашаант	2021	133	125	0	877	886	1.1	1	1.5	0	0.9	1.4
Сайхан	1498	163	200	0	725	410	0.5	0.4	1	0	0.4	0.5
Сэлэнгэ	17	7	4	0	5	1	0	0.1	0	0	0	0
Тэшиг	340	42	85	0	108	105	0.5	0.7	0.5	0	0.4	0.5
Хангал	7	1	6	0	0	0	0	0	0.4	0	0	0
Хялганат	31	0	8	0	11	12	0.2	0	0.2	0	0.2	0.2
Хишиг-өндөр	578	43	58	0	196	281	0.3	0.2	0.4	0	0.2	0.4
Хутаг-Өндөр	116	30	40	0	21	25	0.1	0.2	0.2	0	0	0
Дүн	11633	1015	1511	0	4475	4632	0.4	0.4	0.5	0.0	0.3	0.5

Хорогдсон хээлтэгч, сумаар, 2016 оны 2-р сарын байдлаар

Сум	Өвчнөөр хорогдсон том мал					
	Бүгд	Адуу	Үхэр	Тэмээ	Хонь	Ямаа
Булган	5	0	0	0	5	0
Баян-Агт	32	7	6	0	10	9
Баяннуур	16	2	14	0	0	0
Бугат	36	3	7	0	8	18
Б рэгхангай	44	3	9	0	9	23
Гурван булаг	296	6	10	0	179	101
Дашинчилэн	765	60	153	0	258	294
Могод	1	0	1	0	0	0
Орхон	87	8	7	0	31	41
Рашаант	0	0	0	0	0	0
Сайхан	319	39	43	0	155	82
Сэлэнгэ	0	0	0	0	0	0
Тэшиг	146	13	36	0	52	45
Хангал	2	0	2	0	0	0
Хялганат	0	0	0	0	0	0
Хишиг- нд р	60	8	12	0	5	35
Хутаг- нд р	36	6	11	0	4	15
<b>Дүн</b>	<b>1845</b>	<b>155</b>	<b>311</b>	<b>0</b>	<b>716</b>	<b>663</b>

Өвчнөөр хорогдсон том мал, сумаар, 2016 оны 2-р сарын байдлаар

Сум	Хорогдсон хээлтэгч					
	Бүгд	Адуу	Үхэр	Тэмээ	Хонь	Ямаа
Булган	0	0	0	0	0	0
Баян-Агт	22	3	2	0	9	8
Баяннуур	2	0	2	0	0	0
Бугат	6	0	6	0	0	0
Б рэгхангай	13	1	0	0	5	7
Гурван булаг	0	0	0	0	0	0
Дашинчилэн	0	0	0	0	0	0
Могод	1	0	1	0	0	0
Орхон	0	0	0	0	0	0
Рашаант	0	0	0	0	0	0
Сайхан	0	0	0	0	0	0
Сэлэнгэ	0	0	0	0	0	0
Тэшиг	34	1	15	0	7	11
Хангал	5	0	5	0	0	0
Хялганат	0	0	0	0	0	0
Хишиг- нд р	22	0	0	0	11	11
Хутаг-Өндөр	0	0	0	0	0	0
<b>Дүн</b>	<b>105</b>	<b>5</b>	<b>31</b>	<b>0</b>	<b>32</b>	<b>37</b>



**Холбоо барих**  
Монгол улс, Булган аймаг, Булган  
сум, Засаг даргын тамгын газар,  
Статистикийн хэлтэс  
**Утас:** 70342766  
**И-мэйл:** bulgan@nso.mn  
**вэб:** www.bulgan.nso.mn

**Contact us**  
*Statistical division, Governors office*  
*Bulgan sum, Bulgan aimag, Mongolia*  
**Phone:** 70342766  
**E-mail:** bulgan@nso.mn  
**Web:** www.bulgan.nso.mn